



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Байгаль орчны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/079/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2026.02.25	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: М.Алтантуяа Утас: 99061829 Цахим хаяг: Altantuyam@audit.gov.mn Аудитор: А.Адилзаяа Утас: 80870886 Цахим хаяг: Adilzayaa@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудит хийгдээгүй болно.	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Албан шаардлага	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОУАӨС	Байгаль орчин үүр амьсгалын өөрчлөлтийн сайд
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс



Баянхонгор аймгийн Байгаль
Орчны Газрын Дарга
Б.Бат-Өлзий Танаа

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2026.02.25 № 2/104

танай _____-ны № _____-т

Г **Өөрчлөлтгүй дүгнэлт** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Байгаль орчны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлын онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Баянхонгор аймгийн Байгаль орчны газар нь 2025 онд аймгийн ИТХ-ын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 13/11 дүгээр тогтоолыг үндэслэн 413,820.2 мянган төгрөгийн Шинэ суурьшлын мод үржүүлгийн газрын барилга, тоног төхөөрөмж болон Богд сумын мод үржүүлгийн газар, 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 9/61 дүгээр тогтоолоор 39,950.0 мянган төгрөг, БОУАӨС-ын 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/325 тоот тушаалаар ХБНГУ-ын Засгийн газрын хооронд байгуулсан буцалтгүй тусламжаар үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 106,207.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Тайлант онд Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 4/30 дугаар тогтоолын хавсралтаар “Байгаль орчны газар нь тусгай зориулалтын ангийн дуудлага худалдааны орлогоор 2025 онд аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил арга хэмжээг санхүүжүүлэх зардлын төлөвлөгөө”-г батлуулж, 4 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлээр 236,629.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТӨРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

6477143544
БЮА 0067 9007423

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/төгрөгөөр/	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	855,249,361.28	406,720,967.37
33	АВЛАГА	429,744,069.27	106,654,180.98
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	241,069.27	868,180.98
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	102,166,000.00
335	Бусад авлага	429,503,000.00	3,620,000.00
3351	Байгууллагаас авах авлага	429,503,000.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	3,620,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	218,146,314.01	245,094,786.39
351	Түүхий эд материал	160,925,495.01	173,019,118.39
35110	Тусгай зориулалттай материал	160,925,495.01	173,019,118.39
354	Хангамжийн материал	57,220,819.00	72,075,668.00
35410	Бичиг хэргийн материал	1,810,800.00	1,454,300.00
35420	Аж ахуйн материал	18,806,180.00	13,837,020.00
35440	Түлш, шатах тослох материал	236,239.00	2,912,748.00
35450	Барилгын засварын материал	974,000.00	5,884,000.00
35470	Бусад хангамжийн материал	35,393,600.00	47,987,600.00
36	НӨӨЦИЙН БАРАА	207,358,978.00	54,972,000.00
36100	Барааны нөөц	207,358,978.00	54,972,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	924,203,500.71	1,353,024,083.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	924,203,500.71	1,353,024,083.29
392	Биет хөрөнгө	471,406,250.78	626,836,833.40
39201	Барилга, байгууламж, орон сууц	267,386,709.12	434,336,949.12
39202	Хуримтлагдсан элэгдэл	(39,359,432.80)	(68,496,153.71)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,350,000.00	216,957,687.95
39204	Хуримтлагдсан элэгдэл	(45,374,999.90)	(67,776,494.71)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	275,894,766.66	249,786,670.66
39206	Хуримтлагдсан элэгдэл	(101,990,822.88)	(144,117,413.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,085,550.00	27,086,150.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(27,196,233.92)	(20,940,562.91)
39214	Бусад үндсэн хөрөнгө	45,950,000.00	-
39215	Хуримтлагдсан элэгдэл	(16,339,285.50)	-
393	Биет бус хөрөнгө	452,797,249.93	726,187,249.89
39301	Програм хангамж	7,935,000.00	7,935,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(7,329,083.29)	(7,582,083.25)
39303	Бусад биет бус хөрөнгө	457,858,000.00	744,678,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(5,666,666.78)	(18,843,666.86)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,779,452,861.99	1,759,745,050.66
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	9,000,982.00	43,576,890.20
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,000,982.00	43,576,890.20
413	Өглөг	9,000,982.00	43,576,890.20
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	982.00	227,424.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	9,000,000.00	22,046,866.20
4136	Бусад өглөг	-	21,302,600.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	20,902,600.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	400,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,770,451,879.99	1,716,168,160.46
51	Засгийн газрын хувь оролцоо	1,770,451,879.99	1,716,168,160.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	252,228,714.62	252,228,714.62
51101	Өмч: - төрийн	252,228,714.62	252,228,714.62
512	Хуримтлагдсан үр дүн	1,327,427,998.97	1,273,144,279.44

Байгаль орчны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51210	Өмнөх үеийн үр дүн	1,327,427,998.97	1,327,427,998.97
51220	Тайлант үеийн үр дүн	-	(54,283,719.53)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	190,795,166.40	190,795,166.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,779,452,861.99	1,759,745,050.66

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,667,514,445.21	2,767,385,244.05
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		
120	Нийтлэг татварын бус орлого	91,146,881.21	594,687,844.05
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	350,000.00	920,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	350,000.00	920,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,576,367,564.00	2,172,697,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	951,136,164.00	549,904,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	284,463,164.00	185,260,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	666,673,000.00	364,644,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,625,231,400.00	1,622,793,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,625,231,400.00	1,622,793,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,477,176,173.87	2,787,442,778.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,477,176,173.87	2,787,442,778.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,328,088,945.86	2,551,710,293.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,125,927,912.00	1,152,886,864.12
210101	Үндсэн цалин	639,892,193.43	698,294,426.38
210102	Нэмэгдэл	375,785,224.13	355,120,248.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	57,586,370.00	55,840,000.00
210104	Урамшуулал	52,664,124.44	43,632,188.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,782,288.76	141,722,763.77
210201	Тэтгэврийн даатгал	94,375,873.19	98,596,297.26
210202	Тэтгэмжийн даатгал	11,265,266.10	11,545,885.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,711,650.33	5,772,942.98
210204	Ажилгүйдлийн даатгал	5,085,898.06	5,161,527.78
210205	Эрүүл мэндийн даатгал	20,343,601.08	20,646,110.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,017,010.80	29,012,377.40
210301	Гэрэл, цахилгаан	3,190,556.60	4,287,281.20
210302	Түлш, халаалт	20,856,398.20	21,579,140.20
210303	Цэвэр, бохир ус	1,970,056.00	3,145,956.00
2104	Хангамж, бараа материалын зардал	108,924,013.50	215,554,853.42
210401	Бичиг хэрэг	7,948,700.00	5,524,000.00
210402	Тээвэр, шатахуун	16,340,843.00	8,044,568.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,124,574.00	2,183,320.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,904,100.00	3,158,650.00
210408	Бараа материал акталсны зардал	73,405,796.50	43,057,336.62
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	-	152,386,978.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,799,100.00	15,360,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	343,900.00
210604	Урсгал засвар	16,799,100.00	15,016,550.00
2107	Томилолт, зочны зардал	12,350,000.00	4,900,000.00

Байгаль орчны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	12,350,000.00	4,900,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	440,937,544.00	7,257,136.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	438,753,908.00	6,143,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	327,224.00	406,224.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	1,084,412.00	674,412.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	460,351,076.80	985,015,848.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	357,586,699.00	850,029,688.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	600,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	102,164,377.80	134,986,160.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	149,087,228.01	235,732,485.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	110,476,883.00	157,031,620.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	6,381,720.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,426,600.00	136,093,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	91,080,283.00	14,556,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,970,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	38,610,345.01	78,700,865.20
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,610,345.01	78,700,865.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	190,338,271.34	(20,057,534.84)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	44,708,000.00	3,620,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	44,708,000.00	3,620,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,444,444.52	37,846,184.69
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4,444,444.52	37,846,184.69
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	40,263,555.48	(34,226,184.69)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	230,601,826.82	(54,283,719.53)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,710,176,564.00	2,173,617,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	350,000.00	920,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	350,000.00	920,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	350,000.00	920,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	350,000.00	920,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,709,826,564.00	2,172,697,400.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	133,459,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	951,136,164.00	549,904,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	284,463,164.00	185,260,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	666,673,000.00	364,644,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,625,231,400.00	1,622,793,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,625,231,400.00	1,622,793,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,675,804,564.00	2,117,467,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,675,804,564.00	2,117,467,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,097,214,335.99	1,779,968,914.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,125,360,521.13	1,153,402,439.23
210101	Үндсэн цалин	639,324,802.56	682,305,980.39

Байгаль орчны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210102	Нэмэгдэл	375,785,224.13	371,624,270.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	57,586,370.00	55,840,000.00
210104	Урамшуулал	52,664,124.44	43,632,188.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,899,536.06	141,607,858.37
210201	Тэтгэврийн даатгал	94,493,120.49	98,552,318.08
210202	Тэтгэмжийн даатгал	11,265,266.10	11,545,885.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,711,650.33	5,772,942.98
210204	Ажилгүйдлийн даатгал	5,085,898.06	5,090,601.56
210205	Эрүүл мэндийн даатгал	20,343,601.08	20,646,110.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,017,010.80	28,250,681.20
210301	Гэрэл, цахилгаан	3,190,556.60	4,287,281.20
210302	Түлш, халаалт	20,856,398.20	21,463,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,970,056.00	2,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,349,574.00	15,815,900.00
210401	Бичиг хэрэг	4,450,000.00	3,750,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,000,000.00	6,666,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,199,574.00	2,016,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,500,000.00	2,383,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,728,000.00	8,643,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	38,000.00	343,900.00
210602	Тавилга	190,000.00	-
210604	Урсгал засвар	14,500,000.00	8,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,190,000.00	4,900,000.00
210702	Дотоод албан томилолт	6,190,000.00	4,900,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	441,889,080.00	7,257,136.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	439,705,444.00	6,143,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	327,224.00	406,224.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	1,084,412.00	674,412.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	324,780,614.00	420,091,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	324,180,614.00	420,091,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	600,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	578,590,228.01	337,498,485.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	110,476,883.00	156,631,620.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	5,981,720.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,426,600.00	136,093,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	91,080,283.00	14,556,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,970,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	468,113,345.01	180,866,865.20
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,610,345.01	180,866,865.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	34,372,000.00	56,150,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (34,372,000.00	56,150,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	34,372,000.00	56,150,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	34,372,000.00	56,150,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	34,372,000.00	56,150,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(34,372,000.00)	(56,150,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	/төгрөгөөр/ Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	252,228,714.62	192,131,674.55	834,948,000.40	-	1,279,308,389.57
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,336,508.15	-	1,336,508.15
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	252,228,714.62	192,131,674.55	836,284,508.55	-	1,280,644,897.72
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	260,541,663.60	-	260,541,663.60
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	252,228,714.62	190,795,166.40	1,327,427,998.97	-	1,770,451,879.99
D01	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	252,228,714.62	190,795,166.40	1,327,427,998.97	-	1,770,451,879.99
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	252,228,714.62	190,795,166.40	1,327,427,998.97	-	1,770,451,879.99
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(54,283,719.53)	-	(54,283,719.53)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	252,228,714.62	190,795,166.40	1,273,144,279.44	-	1,716,168,160.46

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,661,279,800.00	1,570,971,434.80	90,308,365.20	94.56
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,660,279,800.00	1,570,051,434.80	90,228,365.20	94.57
132001	Орон нутгийн төсвөөс	1,660,279,800.00	1,570,051,434.80	90,228,365.20	94.57
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	920,000.00	80,000.00	92.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	920,000.00	80,000.00	92.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,661,279,800.00	1,570,971,434.80	90,308,365.20	94.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,661,279,800.00	1,570,971,434.80	90,308,365.20	94.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,513,685,900.00	1,428,895,814.80	84,790,085.20	94.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,199,778,000.00	1,150,252,313.01	49,525,686.99	95.87
210101	Үндсэн цалин	690,815,200.00	682,235,054.17	8,580,145.83	98.76
210102	Нэмэгдэл	398,876,000.00	368,545,070.00	30,330,930.00	92.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	55,953,200.00	55,840,000.00	113,200.00	99.80
210104	Урамшуулал	54,133,600.00	43,632,188.84	10,501,411.16	80.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,972,300.00	141,293,884.59	8,678,415.41	94.21
210201	Тэтгэврийн даатгал	101,981,100.00	98,167,418.08	3,813,681.92	96.26
210202	Тэтгэмжийн даатгал	11,997,800.00	11,545,885.43	451,914.57	96.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,998,900.00	5,772,942.98	225,957.02	96.23
210204	Ажилгүйдлийн даатгал	5,998,900.00	5,161,527.78	837,372.22	86.04
210205	Эрүүл мэндийн даатгал	23,995,600.00	20,646,110.32	3,349,489.68	86.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,963,400.00	28,250,681.20	712,718.80	97.54
210301	Гэрэл, цахилгаан	5,000,000.00	4,287,281.20	712,718.80	85.75
210302	Түлш, халаалт	21,463,400.00	21,463,400.00	00.00	100.00

Байгаль орчны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	2,500,000.00	2,500,000.00	00.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,490,200.00	15,815,900.00	3,674,300.00	81.15
210401	Бичиг хэрэг	4,700,000.00	3,750,000.00	950,000.00	79.79
210402	Тээвэр, шатахуун	8,000,000.00	6,666,400.00	1,333,600.00	83.33
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,184,000.00	2,016,300.00	167,700.00	92.32
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,000,000.00	200,000.00	83.33
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,406,200.00	2,383,200.00	1,023,000.00	69.97
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,425,000.00	10,793,900.00	1,631,100.00	86.87
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,125,000.00	2,493,900.00	1,631,100.00	60.46
210604	Урсгал засвар	8,300,000.00	8,300,000.00	00.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	6,000,000.00	4,900,000.00	1,100,000.00	81.67
210702	Дотоод албан томилолт	6,000,000.00	4,900,000.00	1,100,000.00	81.67
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,957,000.00	7,257,136.00	1,699,864.00	81.02
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,562,500.00	6,143,500.00	419,000.00	93.62
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	-	300,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	450,000.00	-	450,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	526,500.00	406,224.00	120,276.00	77.16
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00	00.00	100.00
210807	Газрын төлбөр	1,085,000.00	674,412.00	410,588.00	62.16
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,100,000.00	70,332,000.00	17,768,000.00	79.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	87,500,000.00	70,332,000.00	17,168,000.00	80.38
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	600,000.00	-	600,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	147,593,900.00	142,075,620.00	5,518,280.00	96.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	147,593,900.00	142,075,620.00	5,518,280.00	96.26
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,500,000.00	5,981,720.00	5,518,280.00	52.01
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	136,093,900.00	136,093,900.00	00.00	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	00.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	00.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	47	47	00.00	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	00.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	39	39	00.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	6	6	00.00	100.00
620004	Гэрээт ажилтан	1	1	00.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	47	47	00.00	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	37	37	00.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	9	00.00	100.00
650010	Гэрээт ажилтан	1	1	00.00	100.00

2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл /төгрөгөөр/
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	421,779,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	421,779,100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	407,223,100.00
210102	Нэмэгдэл	3,079,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,079,200.00
210201	Тэтгэврийн даатгал	384,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	384,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	403,759,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	403,759,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,556,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,556,000.00

213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	128,125,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	549,904,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	549,904,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	185,260,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	364,644,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Байгаль орчны газар нь байгаль орчны багц хуулийг аймаг, орон нутагтаа хэрэгжүүлэх, байгаль хамгаалах, хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн нөөц баялгийг арвижуулах, нөөц даацын хүрээнд зохистой ашиглах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, салбарын байгууллагын үйл ажиллагааг уялдуулан чиглүүлэх, байгаль орчны мэдээллийн санг бүрдүүлэх, судалгаа, шинжилгээ, сургалт сурталчилгааны ажлыг гүйцэтгэж, иргэдийг эрүүл аюулгүй орчинд ажиллаж, амьдрах таатай орчин бүрдүүлэх зорилго бүхий байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт, 77 арга хэмжээ тусгаж ажилласан ба гүйцэтгэлийг 98.4 хувь гэж үнэлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын дотоод аудит/аудиторын чиг үүргийг Баянхонгор аймгийн САНхүүгийн хяналт, дотоод аудитын газар хэрэгжүүлдэг ба тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Байгаль орчны газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, “Төсвийн тухай хууль” болон бусад холбогдох хууль, журмуудыг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Байгаль орчны газар нь 2025 оны санхүүгийн тайланг “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,759,745.0 мянган төгрөг буюу 1.12 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	429,744.1	106,654.2	323,089.9
Бараа материал	218,146.3	245,094.8	(26,948.5)
Нөөцийн бараа	207,359.0	54,972.0	152,387.0
Үндсэн хөрөнгө	924,203.5	1,353,024.1	(428,820.6)
Хуримтлагдсан элэгдэл	(243,256.5)	(327,756.4)	84,499.8
Нийт хөрөнгө	1,779,452.9	1,759,745.1	19,707.8
Өр төлбөр	9,001.0	43,576.9	(34,575.9)
Цэвэр хөрөнгө/өмч	1,770,451.9	1,716,168.2	54,283.7
Засгийн газрын хувь оролцоо/Эздийн өмч	1,770,451.9	1,716,168.2	54,283.7
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмийн дүн	1,779,452.9	1,759,745.1	19,707.8

Авлагын дансны эхний үлдэгдэл 429,744.1 мянган төгрөгөөс оны эцэст орон нутагт төвлөрүүлсэн шонхрын хураамжийн авлага 167,130.0 мянган төгрөг, ангийн дуудлага худалдааны орлогоос орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн 262,373.0 мянган төгрөгийн авлага барагдаж, тайлант оны эцэст 106,654.2 мянган төгрөг байгаа нь ажиллагчидтай холбогдсон авлага 868.2 мянган төгрөг, татаас санхүүжилтийн авлага 102,166.0 мянган төгрөг, тооллогоор дутагдсан үндсэн хөрөнгийг авлагаар тусгаж 3,600.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл байна.

Бараа материал дансны үлдэгдэл тайлант оны эцэст 26,948.5 мянган төгрөгөөр буурсан байгаа нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа материал 101,609.1 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан шатахууны хөнгөлөлтийн урамшуулал 663.9 мянган төгрөг, Байгаль орчны газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/26 дугаар тушаалаар Монгол улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хооронд байгуулсан буцалтгүй тусламжийн хэлэлцээрийн хүрээнд Монгол улсаас хэрэгжиж буй “Биологийн олон янз байдлыг

хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн санхүүжилтээр олгосон 47,601.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан ба байгууллагын үйл ажиллагаанд 79,868.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, нөөцийн бараанд бүртгэлтэй 152,386.9 мянган төгрөгийн бараа материалыг холбогдох шийдвэрийг үндэслэн үндсэн хөрөнгөд бүртгэж, газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/25 дугаар тушаалаар ашиглалтын хугацаа дууссан 43,057.3 мянган төгрөгийн бараа материалыг акталж, данснаас хассан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,353,024.1 мянган төгрөг болж оны эхний үлдэгдэл хөрөнгөөс 428,820.6 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгө 56,150.0 мянган төгрөг, аймгийн ИТХ-ын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 13/11 дүгээр тогтоолыг үндэслэн Даяар трейд ХХК-ий нийлүүлсэн 413,820.2 мянган төгрөгийн Шинэ суурьшлын мод үржүүлгийн үндсэн хөрөнгө болон Богд сумын мод үржүүлгийн газар, 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 9/61 дүгээр тогтоолоор 39,950.0 мянган төгрөг, БОУАӨС-ын 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/325 тоот тушаалаар ХБНГУ-ын Засгийн газрын хооронд байгуулсан буцалтгүй тусламжаар үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 106,207.7 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод бүртгэж, аймгийн ИТХ-ын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 7/40, 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 9/61 дүгээр тогтоолоор 68,946.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлж, 2025 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 7/42, 2025 оны 08 дугаар сарын 256-ны өдрийн 49 дүгээр тогтоолыг үндэслэн 30,241.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, жилийн эцсийн тооллогоор дутагдсан 3,620.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дутагдсан хөрөнгөд бүртгэж, үндсэн хөрөнгөөс хасагдуулсан байна.

Тайлант онд өглөгийн дансны үлдэгдэл 43,576.9 мянган төгрөг болж 34,575.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны төсвийн тодотголоор 192,661.6 мянган төгрөгөөр төсвийг бууруулж, хуваарьт өөрчлөлт оруулснаар цалингийн өглөг 227.4 мянган төгрөг, тогтмол зардлын өглөг 946.9 мянган төгрөг, бусад зардлын өглөг 21,100.0 мянган төгрөг болон бусад өглөг 21,302.0 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Байгууллагын биет бус хөрөнгөд 7,935.0 мянган төгрөгийн дансны үнэ бүхий 3 программ байгаагаас тайлант онд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ий “Acolous” санхүүгийн программын төлбөрт 901.0 мянган төгрөгийг урсгал зардлын төсвөөс төлж, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,514,495.5 мянган төгрөгөөр тооцож Баянхонгор аймгийн БОАЖГ-ын 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 247 тоот албан бичгээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн бөгөөд Баянхонгор аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны 4/28 дугаар тогтоолоор төсвийг

1,859,941.4 мянган төгрөгөөр баталж, 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 8/45 дугаар тогтоолоор 1,661,279.8 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд орон нутгийн төсвийн санхүүжилтээр 1,660,279.8 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 1,000.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 1,623,713.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үүнээс урсгал үйл ажиллагаанд 1,570,971.4 мянган төгрөгийн зарцуулж, 52,741.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,570,971.4 мянган төгрөг буюу нийт батлагдсан төсвийн 94.56 хувийг зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
71413 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх					
1	80801 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,420,623.40	1,353,020.31	67,603.09	95.24
2	80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	1,200.00	781.00	419.00	65.08
3	80219 Харуул хамгаалалтын зардал	5,362.50	5,362.50	-	100.00
4	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	147,593.90	142,075.62	5,518.28	96.26
5	81701 Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх	86,500.00	69,732.00	16,768.00	80.62
Нийт		1,661,279.80	1,570,971.43	90,308.37	94.56

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тус байгууллага нь 2025 онд Байгаль орчны газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/01 дүгээр тушаалаар байгууллагын бүтэц орон тоог удирдах 1, гүйцэтгэх 15, үйлчлэх 6, байгаль хамгаалагч 31, нийт 53 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулахаар баталж, гүйцэтгэлээр 47 албан хаагчтайгаар ажилласан байна.

Тайлант онд байгууллагын хоол, унааны хөнгөлөлтөд улсын төсвөөс 55,953.2 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 55,840.0 мянган төгрөг зарцуулсан байна. Дээрх хөнгөлөлтийн тарифыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 9.3.12 дахь хэсгийг үндэслэн байгууллагын даргын 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн Б/89 дүгээр тушаалаар нэг хүнд ногдох өдрийн тарифыг 20.0 мянган төгрөгөөр тогтоожээ.

3.5.2 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд тайлант хугацаанд дээд шатны төсвийн захирагчаас олгох урсгал шилжүүлэг 185,260.1 мянган төгрөг, Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 4/30 дугаар тогтоолоор өмнөх оны тусгай зориулалтын ангийн дуудлага худалдааны орлогын 50 хувь болох 262,373.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 102,271.0 мянган төгрөг төвлөрч, үүнээс Шинэжинст сумын байгаль хамгаалагчдын орон нутгийн нэмэгдэлд 3,464.1 мянган төгрөг, 5 жилийн тэтгэмж 14,556.0 мянган төгрөг, Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 4/30 дугаар тогтоолоор баталсан тусгай зориулалтын ангийн дуудлага худалдааны орлогоос зарцуулах төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээнд 236,629.0 мянган төгрөг, бусад үйлчилгээний зардалд 167,130.0 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 128,125.0 мянган төгрөгийн орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 4/30 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль орчны газар нь тусгай зориулалтын ангийн дуудлага худалдааны орлогоор 2025 онд аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил арга хэмжээг санхүүжүүлэх зардлын төлөвлөгөө”-нд суудлын автомашин худалдан авах төлөвлөгөө батлуулж, ТБНОНӨХБАУХАТХ-ийн 31 дүгээр зүйл 31.1.1-т заасны дагуу нээлттэй тендер шалгаруулалтыг аргаар БХАБОАЖГ/20250202001 дугаар бүхий авто машин худалдан авах ажиллагаа зохион байгуулж “Түйн голын төгөл” ХХК шалгарсны дагуу 54,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан, хүлээн авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Байгаль орчны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Адилзаяа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Байгаль орчны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 463 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөв болох 1,661,279.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 24,919.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Аудитыг төлөвлөх үе шатанд тус байгууллагад хамаарах Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой 53 эрсдэлийг сонгож бүртгэсэн бөгөөд аудитаар зөрчил илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих цалингийн зардлаас бусад 5 саяас дээш дүнтэй орлогын 1,260,077.5 мянган төгрөгийн 35 гүйлгээ, зарлагын 663,722.0 мянган төгрөгийн 25 гүйлгээ, бусад мэдээлбэл зохих 231 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

2024 оны санхүүгийн тайлангийн аудитыг Төрийн аудитын байгууллагын ахлах аудитор Н.Батчимэг гүйцэтгэсэн бөгөөд аудитаар 1,732.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, тайлант хугацаанд бүрэн биелсэн байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,732.1	1	1,732.1	100
Нийт дүн	1	1,732.1	1	1,732.1	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 22,720.0 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Тайлант онд аймгийн Засаг даргын захирамжаар хэрэгжүүлсэн 4 арга хэмжээний хүрээнд 60,500.0 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн Байгаль орчны газраас авахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 48,400.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үлдэгдэл санхүүжилтийн авлагыг 12,500.0 мянган төгрөгөөр тусгасан буюу 400.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Энэ нь УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүжилтийн авлагын дүнг 12,100.0 мянган төгрөг болгон авлагын тайланд залруулав.

2. Аймгийн ИТХ-ын 2023.02.13-ны өдрийн 13/11 дугаар тогтоолоор БОГ-т Даяар трейд ХХК-ны гүйцэтгэсэн шинэ суурьшлын бүсийн мод үржүүлгийн газрын 127,000.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авахаар тушаасан байхад байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн 2025.05.30-ны өдрийн 04 дугаар хурлын тэмдэглэлээр 7,000.0 мянган төгрөгийн 2 ширхэг зуны хүлэмжийг авах шаардлагагүй гэж үзэж 120,000.2 мянган төгрөгийн өртөг бүхий ширхэг үндсэн хөрөнгийг орлогод авсан байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.3 дахь "жинхэнэ хэрэгжилтийн;" 5.1.4 дэх "үнэн зөв байх;" УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, НББОУС-16 Үндсэн хөрөнгө, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2-т Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 7,000.0 мянган төгрөгийн 2 хүлэмжийг орлогод бүртгэж, үндсэн хөрөнгийн тайланд залруулав.

3. Байгууллагын даргын 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар томилсон тооллогын комисс 2025 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг явуулахад 3,620.0 мянган төгрөгийн дрон тооллогоор дутагдсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, НББОУС-16 Үндсэн хөрөнгө, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тооллогоор дутагдсан 3,600.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дутагдсан хөрөнгөд бүртгэж, авлагаар тусгав.

Аудитаар нийт 3,750.0 мянган төгрөгийн 1 зөрчил² илэрсэнд 3.750.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс материаллаг зөрчил илрээгүй тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

5.1.1 Тайлант онд байгууллагын даргын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн Б/23 дугаар тушаалаар 5 албан хаагчид 3,750.0 мянган төгрөгийн ёс зүйн хорооны нэмэгдэл урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь "Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно" гэсэн заалтыг зөрчиж, уг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь "Төсвийн байгууллага, түүний албан тушаалтан", 3.2 дахь "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө" гэсэн заалтыг дагаж мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, алдааг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд байгууллагын даргын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн Б/23 дугаар тушаалаар 5 албан хаагчид 3,750.0 мянган төгрөгийн ёс зүйн хорооны нэмэгдэл урамшуулал олгосон байна.	1	3,750.0			1	3,750.0		
Дүн	1	3,750.0			1	3,750.0		

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oO-----